МЭДЭЭ · 2025 оны 11-р сарын 17

“ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгээс Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран “Хөдөлмөрлөх эрхийн олон улсын гэрээ, конвенц” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.


Сургалтад "Албадан хөдөлмөрийг устгах тухай олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ, Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын 1930 оны 29 дүгээр конвенцын 2014 оны протокол" сэдвээр ОУХБ-ын Ази, Номхон далайн бүсийн товчооны ахлах мэргэжилтэн Алайн Пельс, "Хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлж, хүүхдийн хөдөлмөрийг устгахад прокурорын байгууллагын оролцоо болон олон улсын сайн туршлага” сэдвээр ОУХБ-ын Ази, Номхон далайн бүсийн товчооны ахлах мэргэжилтэн Барати Флюг нар сургалт явуулж, прокурор, ажилтнуудын сонирхсон асуултад хариулж, харилцан ярилцав.



Энэхүү сургалт нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээ, стандарт, хүний эрхийн суурь зарчмуудын талаарх ойлголт, мэдлэгийг бататган, гүнзгийрүүлэхэд чиглэгдсэн ач холбогдолтой юм.



Албадан болон заавал хийлгэх хөдөлмөрийн нөхцөл байдлыг тогтоох



1. Эмзэг байдлыг далимдуулах
2. Хууран мэхлэх
3. Чөлөөтэй зорчихыг нь хязгаарлах
4. Түсгаарлах
5. Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртүүлэх
6. Айлган сүрдүүлэх, заналхийлэх
7. Бичиг баримтыг нь барьцаалах
8. Цалингаар нь барьцаалах
9. Өрийн барьцаа, төлөөс
10. Тэвчишгүй нөхцөлд ажиллуулж, амьдруулах
11. Хэт уртгасан цагаар ажиллуулах

ОУХБ: Албадан хөдөлмөр байж болзошгүйг илтгэх шинж тэмдэг | International Labour Organization

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/551